

БАТЛАВ: "УБДС" ТӨХК-ИЙН ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР
Б.БАТБАЯР

2019 онд "УБДС" ХК-ийн ажиллагсдад хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг хангахад олгох барааны тодорхойлолт

• Ерөнхий шаардлага

БАГЦ		№	Аюулгүй ажиллагааг хангах барааны нэрс	Хэмжих нэгж	Тоо
1 Өвлийн ажлын хувцас куртка, өмд	1		Өвлийн ажлын хувцас инженер техникийн ажилтан нарт загвар №1	хос	70
	2		Өвлийн ажлын хувцас засварчин тохируулгын ажилтанд загвар №2	хос	166

1. Өвлийн ажлын хувцаст / куртка, өмд / тавигдах шаардлага

- Өвлийн ажлын куртка, өмд нь инженер техникийн ажилтан, засварчин тохируулгын ажилтан тус бүрт өөр өөр байхаар загвар өнгөний сонголтыг тохирч батална.
- Хувцасны хэмжээг нийлүүлэгч хүн тус бүрээр хэмжиж авах ба хэмжээг гэрээ байгуулсаны дараа өгнө.
- Материал нь агаарын болон дулаан солилцоог хангасан, хөлс гадагшлуулах болон чанар стандартын бусад шаардлагагуудыг хангасан байхаар сонгоно.
- Материал нь очинд түлэгдэхгүй, бөөгнөрөхгүй, агшихгүй, өнгө алдаж будаг гардаггүй байна.
- Ажлын куртка өмд нь ажил үйлчилгээ хийхэд биед эвтэйхэн, хүнд хүчир ажил үйлчилгээ хийхэд хөдөлгөөнд саадгүй чөлөөтэй, оёдлын төгсгөл давхар бэхэлгээтэй оёдолтой байна.
- Өвлийн ажлын өмдний салтаа нь сул чөлөөтэй, нурууны хамгаалалттай, мөрөвчтэй, дээшээ өндөр суулттай байна.
- Ажлын куртка нь дулаахан, давхар дотортой, хөдөлгөөнд саадгүй чөлөөтэй, хунирахгүй таталдахгүй, ханцуй нь чөлөөтэй, барихгүй байна.
- Ажлын куртканы дотор нь ширээстэй, дулаан алдахгүй, биед наалдсан эвтэйхэн, малгай нь магнай давсан чөлөөтэй байна.
- Цэвэр даавуун материалыар хийнэ. Мэргэжлийн онцлогт нийцсэн бат бөх чанартай байна. Материалын дээжийг Сорилын төвийн итгэмжлэгдсэн лабораториор шинжлүүлж, материалын орц, ширхэгжилтийн бүрэлдхүүний сорилтын дүн гүйцэтгэлийг ирүүлэх
- Компаний лого тэмдэг, тодруулагч цацуулагчийн хэмжээ, халаасны хэмжээ хэлбэрийг тохирч хийнэ.